



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Г Цахим хуудасны хайлтын системийн оновчлолын ажил гүйцэтгүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн 2.4.8, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын [www.ulaanbaatour.mn](http://www.ulaanbaatour.mn) цахим хуудасны хайлтын системийн оновчлол /Search engine optimization/-ын ажлыг гүйцэтгэх бага үнийн санал ирүүлсэн Модив софт ХХК-тай хуульд нийцүүлэн гэрээ байгуулж ажиллахыг Мэдээллийн төвүүд хариуцсан менежер /Э.Золзаяа/-д үүрэг болгосугай.

2. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөв болох 30,000,000 /Гучин сая/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА